

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



**УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР**

2026 ОНЫ 5 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРОО**

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 5 дугаар сарын 05-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 12
1. <i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/</i>	7
2. <i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/</i>	8
3. <i>Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал</i>	8 – 12

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
5 дугаар сарын 05-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 35 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

*Томилолттой: Э.Болормаа;
Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, М.Бадамсүрэн, Б.Жаргалан, Г.Очирбат,
Л.Оюун-Эрдэнэ, Д.Цогтбаатар, С.Эрдэнэболд, Р.Эрдэнэбүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Бум-Очир, Б.Тулга.*

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хэлэлцэх асуудлын дараалалд орсон Байнгын хорооны тогтоолын төсөл батлах тухай хоёр асуудлыг нэг, хоёр дахь асуудал болгон хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх С.Дунжидмаа, М.Отгон, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс ирүүлсэн саналыг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асуугаагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар Дэд хорооны бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудлыг долоо хоногоор хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 11
Бүгд: 18
38.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Г.Тэмүүлэн: Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэгийг оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 26 минут үргэлжилж, 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр 12 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 5 дугаар сарын 05-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “ИХ ЗАСАГ” танхим
11 цаг 35 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн энэ өглөөний мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Ирцийг танилцуулъя.

Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Батын Батбаатар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Лувсаннъямын Гантөмөр гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирснээр 5 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны ирц бүрдсэн байна.

51.7 хувьтайгаар бүрдсэн байна.

Хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Гурван асуудал байгаа.

— **Нэгдүгээрт**, “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл байна.

— **Хоёрдугаарт**, Байнгын хорооны тогтоолын төсөл. Ажлын хэсэг байгуулах тухай.

Улсын нисэхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Засгийн газраас өргөн барьсан. Үүнтэй холбоотойгоор ажлын хэсэг байгуулахаар тогтоолын төслийг Та бүхэнд танилцуулах гэж байна.

— **Гуравдугаарт**, Яг энэ асуудалтай холбоотойгоор тухайн ажлын хэсгийн ажиллах “Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа. Ийм гурван асуудалтай байна.

Гурван асуудалтай холбоотойгоор саналтай гишүүн байна уу? Б.Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай.

Үүнийг долоо хоног хойшлуулах хэрэгтэй байна.

Нэгдүгээрт нь, энэ дэд хороо маань 5 хүнтэй жил хагасын өмнө байгуулагдаж байсан. Одоо 5 хүнээрээ байна уу, хэдүүлээ байна.

Тэр үед уг нь анхны төсөл нь 7 хүнээр гэж орж ирээд, тэгээд горимын санал гэж гаргаж байгаад 5 хүнтэй болгосон юм.

Тэгэхээр Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүд, дээрээс нь Засгийн газар 3 дахь удаагаа өөрчлөгдлөө. Ингээд өөрчлөлтүүд орж байгаатай холбоотой энэ дэд хорооны бүрэлдэхүүний тоог 7 болгох. Дээрээс нь төлөөллүүдийг хангах чиглэлд ажиллаж тодорхой шийдвэр, саналуудыг саналаа нэгтгэж байгаад оруулж ирж дараагийн хурлаар хэлэлцье гэсэн ийм санал оруулж байна.

Тэгэхгүй ингээд протоколоос үзвэл хачин хогийн юм ярьж байгаад л дэд хороог 5 болгосон шүү дээ.

Бид тэр хурал дээр сууж байсан. Санаж байгаа.

Г.Тэмүүлэн: Б.Батбаатар гишүүн санал гаргаж байна.

Би бас нэг ийм горимын санал гаргах гээд байна. Хоёр, гуравдугаар асуудлыг эхлээд хэлэлцэж байгаад дэд хорооны бүрэлдэхүүнтэй холбоотой асуудлыг гурав дахь асуудал болгоод хэлэлцээд явъя.

Тэгээд түүн дээр тодорхой Байнгын хорооныхоо хуралдаанаар энэ бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудлуудыг нь дотроо ярилцаад явъя.

Тэгээд шаардлагатай тохиолдолд бид зөвшилцөж байгаад эргээд шаардлагатай бол хойшлуулах асуудлыг хэлэлцээд явъя л гэсэн ийм саналтай байна.

Тэгэхээр би Байнгын хорооны тогтоолын төсөл батлах хоёр асуудлаа нэг дэх, хоёр дахь асуудал болгоод хэлэлцээд явъя гэсэн горимын саналыг гаргаж байна.

Тэгээд гурав дахь асуудал дээр Б.Батбаатар гишүүн нээлттэй энэ асуудлаа хэлэлцээд яваад, тэгээд тэр хүрээндээ.

Хэлэлцэж эхэлчхээд тэндээ шийдлээ олоод явах уу? Тэгэх үү. Тэгье.

Тэгвэл саяын горимын саналаар хоёр дахь, гурав дахь асуудлыг нэг дэх, хоёр дахь асуудал болгох горимын саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалтыг бэлтгэе.

Санал хураалт явуулъя. Дэмжье гэдгээр санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар дэмжигдлээ.

Ингээд хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт орлоо. Нэгдүгээр асуудал руугаа оръё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Ажлын хэсэг байгуулах тухай/

Нэгдүгээр асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл хэлэлцэх. Ажлын хэсэг байгуулах тухай байгаа.

Байнгын хорооны гишүүдэд ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг хүргүүлсэн байна.

Улсын нисэхийн тухай хуулийг манай Байнгын хороо 4 сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн байгаа. Шинэчилсэн найруулгын төслийг.

Ингээд чуулганы хуралдаанаар 5 сарын 01-ний өдөр хэлэлцсэн.

Бид анхны хэлэлцүүлэгт бэлтгэх үүднээс энэ асуудлууд дээр тодорхой ажлын хэсэг байгуулах нь зүйтэй гэсэн саналтай байгаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн дээр тодорхой гишүүд саналаа ирүүлсэн байна. Нэргүйгээр Та бүхэнд тараасан.

Бүрэлдэхүүнтэй холбоотойгоор саналыг танилцуулъя.

Ажлын хэсгийн ахлагчаар Чинбаатарын Анар гишүүнийг оруулах саналтай байна.

Ажлын хэсгийн гишүүдэд Н.Батсүмбэрэл гишүүн, М.Бадамсүрэн гишүүн, П.Наранбаяр гишүүн, Х.Тэмүүжин гишүүн, Л.Энхнасан гишүүн гэсэн ийм 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр оруулах саналтай байна.

Тогтоолын төсөлтэй холбоотойгоор саналтай гишүүд байгаа юу? Алга байна. /алх цохив/

Тэгвэл “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураалтад бэлтгэе. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалт 62.5 хувиар дэмжигдлээ.

Ингээд “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Цаглавар батлах тухай/

“Цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Та бүхэнд танилцуулсан байгаа. Үүнтэй холбоотойгоор Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон хамт өргөн мэдүүлсэн мэдүүлсэн төслүүдийг хэлэлцэх асуудлын цаглаварыг оруулж өгсөн байгаа.

Хавсралтаар цаг хугацааг нь зааж өгсөн байна.

5, 6 сард ажлын хэсэг ажиллаад, ингээд 6 сар эхэн гэхэд оруулж ирэхээр ийм цаглавартайгаар оруулж ирсэн байгаа.

Уг Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбоотойгоор саналтай, асуулттай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Тэгвэл “Цаглавар батлах тухай” тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураалтад бэлдэж байна. Санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар дэмжигдлээ. Ингээд тогтоолын төсөл батлагдлаа. /алх цохив/

**Гурав.Дэд хорооны бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай асуудал**

Гурав дахь асуудалдаа орьё. “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4-т дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүн харьяалах Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарвал тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөх тогтоол баталсанд тооцно гэж заасан байгаа.

Энэ дагуу 2006 оны 09 дүгээр тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсөн юм байна.

Ингээд энэ дагуу дэгийн тухай хуулийн 22.4-т заасны дагуу дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөн байгаа юм байна.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн чөлөөлөгдсөнтэй холбогдуулаад бүрэлдэхүүний асуудлыг шийдвэрлэх асуудал байгаа.

Дэд хорооны бүрэлдэхүүнд орон гарсантай холбоотойгоор тухайн холбогдох намын бүлгээс саналаа ирүүлсэн.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн Монгол Ардын намыг төлөөлж байсан учраас тухайн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт даргад санал хүргүүлэх тухай гээд 5 сарын 05-ны өдрийн 128 тоот бичгээр.

Би Та бүхэнд уншаад танилцуулъя.

Санал хүргүүлэх тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны харьяа Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярыг чөлөөлж Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэгийг оруулах саналыг хүргүүлж байна.

Бүлгийн дарга Ж.Батжаргал гэсэн ийм бичгээр ирүүлсэн байгаа юм байна.

Ингээд орон гарч оруулах энэ асуудалтай холбогдуулаад дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлаар асуулт асуух гишүүд байна уу? Асуулт, санал байгаа. Тусдаа.

Асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. /алх цохив/

Батын Батбаатар гишүүнээр тасаллаа. Б.Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: С.Лүндэг гишүүн байгаа юу? Байна шүү дээ. Харсангүй.

Бид чинь Байнгын хороо дарга, цэргээ зохион байгуулалтаа хийчхээд дараа нь дэд хороо байгуулагдаад, дэд хороодын бүрэлдэхүүнийг байгуулах үед Их Хурлын дарга руу бичиг тал талаас очоод, намуудын бүлгүүд болон намуудаас очоод тэгээд 7 хүний бүрэлдэхүүнтэй хийхээр болж байсан юм. Бүрэлдэхүүнийг нь 7 байлгая гээд.

Тэгж байгаад горимын санал гаргаад Ж.Энхбаяр гишүүн тэр үед санал гаргаад тэгээд өөрчлөлт оруулаад 5 болгоод 5 дээр санал хураагаад ингээд явсан.

Тэгэхээр тэр үеийн протокол дээр яг тийм сонин үгээр горимын санал нь гарсан. Одоо тэрийг дахин давталтгүй.

Тийм болохоор энэ бүрэлдэхүүн дээрээ С.Лүндэг гишүүн дээр эсэргүүцээд байгаа юм алга байна.

Бүрэлдэхүүнээ дахиж нэг ярьж байгаад 7 гэдэг тоогоор дараагийн байнгын хорооны хурлаар оруулаад. Хэрвээ болж байвал тэгээд тэр үедээ С.Лүндэг гишүүнийг хамтад нь нэг мөр оруулаад, ингээд нэг эцэслээд.

Тэр дэд хороо нь хуралдахад мэдээж олонх цөөнхөөрөө тэгээд л бараг дарга нь ойлгомжтой биз. Тэгээд шийдээд явбал яасан юм бэ. Нэг долоо хоног хойшлуулаад. Тийм. Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар ярьж гээд.

С.Бямбацогт даргатай ч гэсэн түрүүн нэг ярихад хэдүүлээ нэг хамт суугаад ярилцаадахья л гээд л тэгж байгаа юм.

Уг нь Ж.Батжаргал болон О.Цогтгэрэл дарга нарт бас хэлсэн байгаа. Үүнийг бүгдээрээ ярилцъя. Дундаа яриад даргын дэргэдэх зөвлөл дээрээ бүлгүүдийн дарга нар яриад ойлголцоод, яавал зөв юм, нэг шийдэл гаргая гээд дөнгөж саяхан би С.Бямбацогт даргатай ярьсан.

Тэгэхээр үүнийг нэг долоо хоног хойшлуулчхаач ээ гэдэг санал горимын санал байгаа юм. Тэгээд оруулъя.

Г.Тэмүүлэн: Б.Батбаатар гишүүн. Горимын санал, томьёоллоо. Та саналаа хэлэх ёстой. Б.Батбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Батбаатар: Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай гээд Б.Энхбаяр бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор нэр оруулахаар орж ирж байна. Монгол Ардын намын бүлгийн даргын албан бланк дээр нэр орж ирсэн байна.

Хүн дээр нь хэлэх зүйл алга байна. Гэхдээ нэгэнт ингэж бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байгаа, энэ асуудлыг дахиж хэлэлцэж байгаа учраас Засгийн газар 3 удаа солигдлоо. Маш олон гишүүд сайд нар өөрчлөлт орсон.

Байнгын хороодын бүрэлдэхүүнд нэлээдгүй өөрчлөлтүүд орж байна. Тэгээд энэ нөхцөл байдалтайгаа уялдуулаад Улсын Их Хурлын 126 гишүүн ижил тэнцүү эрх бүхий 126 гишүүн байгаа. Ижил төрлийн парламентад суудалтай улс төрийн хүчнүүд байгаа.

Тийм болохоор энэ асуудал дээрээ даргын дэргэдэх зөвлөлөөр Тусгай хяналтын дэд хорооны тоог өөрчлөх асуудлыг ярилцаад, өөрчилбөл өөрчлөөд өөрчлөхгүй бол тэр биз. Тэгээд өөрчлөөд төлөөллүүдийг оруулаад тэгээд 7 гэсэн бүрэлдэхүүнтэй байвал зөв болов уу гэсэн бодолтой байгаа юм.

Тэгэхээр энэ бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг дараагийн долоо хоног хүртэл хойшлуулахаар ийм горимын санал оруулж байна. Тэгээд үүнийг санал хураалгаж өгөхийг хүсье.

Г.Тэмүүлэн: Б.Батбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг явуулъя.

Бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудлыг долоо хоногоор хойшлуулъя гэсэн горимын саналыг гаргаж байгаа юм байна.

Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтыг явуулъя.

Б.Батбаатар гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэдгээр санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

38.9 хувиар дэмжигдсэнгүй. /алх цохив/

Тэгэхээр Б.Батбаатарт гишүүн ээ. Өмнө нь намар яригдаж байсан асуудал, манай Байнгын хороон дээр ч яригдсан асуудал, даргын зөвлөл дээр ч яригдсан асуудлууд.

Тэгэхээр энэ долоо хоногийн даргын зөвлөлийн хурлаар энэ асуудлыг хэлэлцэх асуудал болгоод, бүх намуудын төлөөлөл болоод Байнгын хорооны дарга нар ярилцах нь зүйтэй байх гэсэн ийм байр суурьтай байна. Тодорхой энэ асуудлууд дээр ойлголцож, зөвшилцлийн хүрээнд шийдвэрлээд явах нь зүйтэй байх.

Бүрэлдэхүүнтэй холбоотой асуудал мэдээж нээлттэй.

Өнөөдөр зөвхөн Ардын намын бүлгээс орон гарсантай холбоотойгоор чөлөөлөгдөж байгаа гишүүнийхээ оронд С.Лүндэг гишүүнийг оруулах саналыг оруулж ирж байна. Тэгээд чуулганаар орно.

Дараа долоо хоногт мэдээж дэд хорооны дарга өөрөө чөлөөлөгдсөнтэй холбогдуулаад дахиад дэд хорооны дарга томилох асуудлууд орно.

Тэгэхээр Байнгын хороогоор болон чуулганаар мөн дахин авах асуудлууд байгаа. Хоёр долоо хоног угаасаа энэ асуудал хэлэлцэгдэж байгаа учраас энэ асуудал нээлттэйгээр би үлдлээ гэж ойлгож байгаа шүү.

Даргын зөвлөл дээр энэ асуудлуудыг хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулаад яриад явъя гэсэн саналтай байгаа.

Орон гарч байгаа гишүүний нэрийг танилцуулсан.

Баттөмөрийн Энхбаяр гишүүний оронд Монгол Ардын намын бүлгээс Тусгай хяналтын дэд хороонд Сүрэнжавын Лүндэг гишүүнийг оруулахаар ирүүлсэн байна.

Гишүүд асуулт асууж дууссан. Санал хураалтад бэлтгэе.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэг гишүүний оруулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалт. /алх цохив/

72.2 хувиар дэмжигдлээ. /алх цохив/

Ингээд “Дэд дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя.

“Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.9 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэгийг Тусгай хяналтын дэд хорооны гишүүнээр баталсугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн мөрдсүгэй гэсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл байна.

Ингээд хэн уншиж танилцуулах саналтай гишүүд байна уу? Чуулганы хуралдаан дээр. Н.Батсүмбэрэл гишүүн.

Ингээд дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл гишүүн танилцуулна. /алх цохив/

Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Хуралдаан 26 минут үргэлжилж, 12 цаг 01 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД